БАТЛАВ: ЗАСАГ ДАРГА Б.БАТСАЙХАН

2023 ОНЫ СУМЫН ОНХС-ЫН ХӨРӨНГӨӨР НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ХУДАГ ГАРГАХ ЦЭВЭР УСНЫ ХОЛБОЛТ ХИЙХ АЖЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, АЖЛЫН ДААЛГАВАР

| № | | 2023.05.02 |
|---|---|---|
| 1 | **Захиалагчийн нэр** | Увс аймгийн Зүүнхангай сумын ЗДТГ |
| 2 | **Бараа, ажил, үйлчилгээний нэр** | Ногоон багйууламжийн усалгааны худаг гаргах, цэвэр усны холболт хийх |
| 3 | **Тендер шалгаруулалтын дугаар** | УВАЗХСЗДТГ/202312021 |
| 4 | **Техникийн тодорхойлолт** | |
| | А. Зориулалт | Сумын ногоон байгууламжийг усжуулах |
| | Б. Хэрэглээ | Ногоон байгууламж услах, ЗДТГ-ын цэвэр усанд холбох |
| | В. Чанарын түвшин | Увс аймгийн Зүүнхангай сумын ЗДТГ-ын хашааны хайгуултай цэгт гүн өрмийн 1ш худаг шинээр гаргах ажлыг гүйцэтгэхэд худгийн цооног өрөмдөх, тоног төхөөрөмж суурилуулах ажилд тавих техникийн шаардлага MNS 6088:2011, худгийн цооногийн хийц, зохиомж стандартыг мөрдлөг болгон доорх нөхцлийг хангаж ажиллана. |
| | Д. Техникийн үзүүлэлт | **1. Цооног өрөмдөх, цооногийг тоноглох**<br>- Геофизикийн судалгаа хийж, худгийн байршлыг эцэслэн тогтоох<br>- Цооногийн ашиглалтын ундарга: нэг цагт 2мз-аас дээш ус өгөх хүчин чадалтай<br>- Суултын яндангийн материал нь ган эсвэл хуванцар хоолой байна.<br>- Шүүрийн яндангийн материал нь ган эсвэл хуванцар хоолой байна.<br>- Ус өргөх яндангийн диаметр 30мм-ээс багагүй залгаасгүй байна.<br>- Ус шүүх хайрга нь шигшсэн, мөлгөр хэлбэртэй, тоосонцор хольцгүй, мөхлөгийн хэмжээ 9мм-ээс томгүй байна.<br>- Тунгаагуурын гүн: 2м-ээс багагүй<br>- Худгийг шавхалт хийж цэвэрлэх хугацаа: 24 цагаас багагүй<br>- Усны чанарын сорилт авах шинжилгээ хийлгэх<br>**2. Худгийн насос, генератор, цахилгааны утас**<br>- Гүний насос: ISO9001 стандартын шаардлага хангасан. Монгол орны уур амьсгалын нөхцөлд ашиглах боломжтой байх.<br>- Цахилгааны утас: 3-4 салаа, ус чийгний хамгаалалтай, худагт ашиглах шаардлагыг хангасан, насосноос хянах самбар хүртэл үргэлжилсэн (залгаасгүй), ус өргөх яндaнд 2м тутамд хавчиж (туузаар ороож болохгүй) тогтооно.<br>- Худгийн цахилгааныг сумын төвийн төвлөрсөн системд холбох ба цооногийн дэргэд шон хийж худгийн тоолуурыг /хянах самбар/ байрлуулна.<br>**3. Худгийн холболт** |

| | | |
|---|---|---|
| | | - Худгийн цооногоос ЗДТГ-ын байр хүртэл /80м/ ил холболтыг хийж өгнө. Холболтын хоолойн диаметр нь 30мм-ээс багагүй байх<br>- ЗДТГ-ын байранд усны нөөцийн савыг байрлуулна. Нөөцийн савны багтаамж нь 1.5тн-оос багагүй байх ба усны саванд ус өргөлтийн мэдрэгч суурьлуулна. Усны сав нь хуванцар байж болно. Эрүүл ахуйн шаардлага хангасан ундны хэрэглээнд хэрэглэж болох стандартыг хангасан байна.<br>- Нөөцийн савааc ЗДТГ-ын цэвэр усны системд холбох ажлыг хийнэ.<br>- Мөн худгийн цооногоос гудамж хүртэл 140м ил хоолой татах ба хоолойн диаметр нь 30мм-ээс багагүй байна. Хоолойд усны хаалт хийж өгнө.<br>**4. Худгийн ажлыг дуусгаж хүлээлгэж өгөх**<br>- Худгийн паспортыг бэлтгэх<br>- Талбайг цэвэрлэх /өрөмдлөгийн шлам, барилгын болон ахуйн хог хаягдал гэх мэт/<br>- Худаг, гүний насос, ажиллуулах, үйлчилгээ хийх талбайн сургалт хийх<br>- 200м урттай ус дамжуулах уян хоолой дагалдуулж өгнө. |
| | Е. Тоо хэмжээ | 1ш худаг |

Ажлын хэсэг